



ДУНГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2015 оны 04 сарын 13 өдөр

Дугаар 19

Мандалговь

Хөрөнгө худалдах тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар зүйлийн 77.2.3, 77.3 заалт, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 тоот тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 5 дугаар зүйлийн 5.2.1, 5.8.а дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 10,857,000 /арван сая найман зуун тавин долоон мянга/ төгрөгийн анхны өртөгтэй, элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны өртөгөө нөхсөн Дуа 29-29 улсын дугаартай Уаз-469 маркын автомашиныг актлан данс бүртгэлээс хасахыг зөвшөөрсүгэй.

2. Актлагдсан хөрөнгийг 100'000 /нэг зуун мянга/ төгрөгөөр худалдаж хөрөнгө худалдсанаас орох орлогыг 100 хувь Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 080000962 тоот дансанд төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн албаны дарга П.Очирбатад үүрэг болгосугай.

3. Худалдсан эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу данс бүртгэлээс хасахыг Хүүхэд, гэр бүлийн хэлтсийн дарга Л.Оюунбаярт даалгасугай.

ДАРГА  С.БУДЖАВ



0100047